

АНХДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 46 (2310)

1974 оны 6 дугаар сарын 17

ДАВАА

20 ХОНОГИЙН ӨМНӨ

Аймгийн Авто тээврийн XIII баазын хамт олон авто тээвэр байгуулагдсаны хагас зууны ойг угтаж социалист уралдаан өрнүүлэн энэ оны эхний хагас жилийн төлөвлөгөөгөө 20 хоногийн өмнө 100,2—460,8 хувиар, бүх ард түмний уралдаанд авсан үүргээ 100,0—450,6 хувиар биелүүлж сайхан амжилт гаргав.

Шууданчдаас Ч.Намрайжав, шууданч Ө.Шагдар, тээвэрчдээс Ж.Цэрэндорж нар V таван жилийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлээд үлдэж буй хугацаанд 2—3 жилийн ажил хийх зорилт тавиад тээвэрчин нөхдөө хошуучилж явна.

С.ОТГОН

Арвин тэжээл БЭЛТГЭЛЭЭС ШАЛТГААЛНА

Манай аймаг энэ онд байгалийн хадлан 95,7, таримал тэжээл 74,1, үүнээс дарш 57,7 мянган тонныг тус тус бэлтгэх юм. Тус аймгийн хөдөлмөрчдийн шаргуу хөдөлмөрийн үрээр сүүлийн 4 жилд хадлангийн төлөвлөгөөг 100,5—121,0 хувиар биелүүлж ирсний дотор хадлан тэжээл бэлтгэх ажлыг механикжуулах, хөдөлмөр зохихон байгуулалтыг сайжруулах талаар Жаргалант, Угтаалын САА, Өндөрширээт, Мөнгөнморьт зэрэг олон сум бусдаасаа давуутай ажиллажээ.

Энэ жил аймгийн төлөвлөгөөт хадланг бэлтгэхэд шаардагдах тракторын 91,5, трактор хадуурын 54, тармуурын 64, хаман боогчийн 42,5, морин хадуурын 48, тармуурын 54 хувийг засварлаад байна.

Жаргалантын САА, Баян, Бүрэн сумдын нэгдэл хадлангийн техникийн засвараа амжилттай дуусгаад байна.

Өнгөрсөн онд авсан нийт хадлангийн 60 хувийг өвч механикжсан аргаар бэлтгэж байсан бол энэ жил хадлангийн механикжсан бригад 1, салаа 4-ийг нэмж авсанаар аймгийн хэмжээгээр бэлтгэх хадлангийн 73 хувийг механикжсан аргаар бэлтгэх бололцоотой болоод байна. Зарим газар энэ бололцоог бүрэн ашиглаж, хадлан тэжээлийн бэлтгэлийг эртнээс хангахгүй цаг алдах явдал гарч байгааг анхаарвал зохин.

Батсүмбэр, Эрдэнэ, Лүн, Баяндэлгэр суманд хадлангийн техник засвар эхлээгүй, энэ талаар аж ахуй, зохион байгуулалтын ямарч ажил зохиогоогүй байна. Одоогоор салхи ихтэй, хур бороо бага байгаа тул хөрсний нөөц чийг ихээр алдагдаж, газрын гарц сайнгүй байгаад дүгнэлт хийж, хадлан тэжээл бэлтгэх ажлыг амжилттай шийдвэрлэх үндсэн нөхцөл болсон бэлтгэл ажлыг шуурхайлан хангах явдал одоогийн гол зорилт мөн.

Юуны өмнө таримал тэжээл тариалах төлөвлөгөөг төрөл бүр дээр нь биелүүлэн арчилгааг тогтмол хийж, ялангуяа даршны ургамлын арчилгаа усалгааг гра- төлөвлөгөөний дагуу хугацаанд нь чанартай хийх нь чухал байна.

Хадлангийн талбайн чулууг түүх, элдэв нүх, довндуулыг тэгшлэх, услах бордох, зурваслан хадах зэргээр ургацыг нэмэгдүүлэх системтэй арга хэмжээнийг авч хадлангийн талбайн хуучин хаягдал, с, бухал нурууны үлдэгдлийг хамж цэвэрлэн хамгаалах хэрэгтэй.

Өвсний хаман боогч олонтой эвдэрч олон цагаар сул зогсдог байдлыг анхаарч уг машиныг чадамгай эзэмшдэг тэргүүний хүмүүсийг оролцуулан үзүүлэх сургууль, семинар зохиох нь зүйтэй. Хадланг заавал 7 дугаар сарын дунд ортол хүлээж суухгүй, ойнодоор хой, гол нуур, намгийн захын ургацыг 6 дугаар сарын сүүлчээр хадах, хатааж сүлжин агуулах саваанд хадгалах, өвсний голоор шорлон хөндийлж, бага багаар боөрөнхий хэлбэртэй нуруулах зэргээр аль болохоор чанартай витаминт өвс бэлтгэхэд анхаарах хэрэгтэй.

Хадланд ажиллах агт морьдыг сургах, зүгшрүүлэх, гар хадлангийн багаж хэрэгслийг эртнээс бэлтгэж өвсний тооцоог өдөр тутам хөтлөж, хөдсийг 15 хоног тутам олгох, хадланчдыг ус бороо нэвтрэхгүй ор байраар бүрэн хангаж, сайн чанарын хоол ундар үйлчлэх нь чухал байна.

Хадланч, механикжуулагч нэгбүрээр социалист уралдаанд үүрэг амлалт авахуулж, богино хэлбэрийн уралдаан зохиож, явцыг 5,7 хоногоор дүгнэн нийтэд мэдээлж байх хэрэгтэй.

Хадлан тэжээл, бэлтгэх ажилд бүх нийтийг татан оролцуулахад онцлон анхаарч чанар сайтай арвин тэжээл бэлтгэх урьдчилсан бэлтгэлийг яаравчлан хангах явдал нам, улс, олон нийт, аж ахуйн байгууллагуудын өнөөгийн ээлжит зорилтын нэг болж байна.

Аймгийн ҮЭ-ийн XVII бага хурлын тухай СОНСГОЛ МЭДЭЭ

Аймгийн ҮЭ-ийн XVII бага хурал 1974 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Зуунмод хотод болов. Бага хуралд аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн тайлан илтгэлийг аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн дарга Н.Шагдардагва, шалган байцаах комиссын тайлан илтгэлийг шалган байцаах комиссын дарга Т.Цэдэв нар тавьж хэлэлцүүлэв.

Бага хуралд аймгийн Намын хорооноос ирүүлсэн баярын бичгийг аймгийн Намын хорооны хоёрдугаар нарийн бичгийн дарга Д.Дамбажамц уншиж гардуулав. Бага хуралд тавигдсан тайлан илтгэлүүдтэй холбогдуулж бага хурлын төлөөлөгч, Тээврийг удирдах газрын дарга Ц.Сэр-Од, Лүн сумын намын үүрийн нарийн бичгийн дарга А.Гончиг, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, Жаргалантын сангийн аж ахуйн тракторч-комбайнч М.Чойжамц, БНМАУ-ын аварга малчин, Батсүмбэрийн сангийн аж ахуйн саальчин М.Амаржаргал, Анхдугаар таван жил сонины хариуцлагатай эрхлэгч Д.Товуу, Борнуурын сангийн аж ахуйн ҮЭ-ийн зөвлөлийн дарга Д.Ёндон, Сэргэлэн сумын ХБ ангийн дарга Д.Дансран, Усны аж ахуй удирдах газрын дарга Г.Довдон нарын 20 гаруй хүн үг хэлэв.

Бага хурал хэлэлцсэн асуудлуудтай холбогдож гарсан тогтоолыг санал нэгтэй батлав. Бага хурал зохион байгуулалтын асуудал хэлэлцэж аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн бүгд хурлын гишүүдийг 75, шалган байцаах комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэй сонголоо.

Бага хурлаас аймгийн Намын хороонд илэрхийлэлт явуулсныг төлөөлөгчид санал нэгтэй батлав.

Аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн анхдугаар бүгд хурал болж, аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн тэргүүлэгчдийг 9 хүний бүрэлдэхүүнтэй сонгож, аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн даргаар Н.Шагдардагва, нарийн бичгийн даргаар П.Очирбат нарыг батлав. Мөн шалган байцаах комиссын даргаар аймгийн Намын хорооны санхүү аж ахуйн тасгийн эрхлэгч Л.Дашлхагвааг баталлаа. Бага хуралд МУЭ-ийн Төв Зөвлөлийн гишүүн, Төв Зөвлөлийн ерөнхий хэлтсийн эрхлэгч Ц.Баасанхүү, аймгийн Намын хорооны товчооны гишүүн, аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны нэгдүгээр орлогч дарга Х.Дамдин нар оролцож дэлгэрэнгүй үг хэлэв.



Саяхан Зуунмод хотод төв, хөдөөгийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга нарын семинар, зөвлөлгөөн болж харилцан туршлага солилцлоо. ЗУРАГ ДЭЭР: Тэргүүний ажиллагаатай эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга нар (зүүн гараас) Баяндэлгэрийн Н.Пагамжав, Алтанбулагийн С.Цэнд, Жаргалантын Л.Насанхүү, аймгийн Эрүүлийг хамгаалах газрын Б.Хишигт, Өндөрширээтийн Ц.Долгоржав, Баянчандманий Х.Баярсүрэн, Угтаалын Ш.Насанхүү нар

Л.ГУНГААБУУ, Л.ДАМДИН ДОРЖ нарын авсан гэрэл зураг

Аймгийн ҮЭ-ийн XVII бага хуралд аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн дарга Н. ШАГДАРДАГВЫН тавьсан илтгэл*

НӨХӨД ӨӨ!

Аймгийн ҮЭ-ийн XVI бага хурлаас хойш хоёр жил гаруй хугацаа өнгөрлөө.

Энэ хугацаанд аймгийн ҮЭ-ийн зөвлөл, МҮЭ-ийн X их хурал, Төв Зөвлөлийн болон аймгийн Намын хорооны бүгд хурлуудаас дэвшүүлсэн зорилт, аймгийн ҮЭ-ийн XVI бага хурлынхаа шийдвэрийг биелүүлэхэд ажлаа чиглүүлж ирлээ.

Манай орны хөдөлмөрчид МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг амжилтаар угтхаар шаргуу хөдөлмөрлөж байгаа үед бага хурал болж байна.

НЭГ. МАХН-ын эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэн, нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд ҮЭ-ийн ажлыг чиглүүлэе

НӨХӨД ӨӨ!

Тайлангийн хугацаанд аймгийн ҮЭ-ийн зөвлөл аймгийн аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, хүмүүсийн хөдөлмөрт социалист ёсоор хандах үзлээр хүмүүжүүлэх, хөдөлмөрийн сахилга батыг бэхжүүлж хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд үйлдвэр олон түмний ажлаа чиглүүлж ирэв. Ялангуяа нийт салбарт үйлдвэрлэлийн үр ашиг, чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх талаар МАХН-ын Төв Хорооны V, VIII, VII бүгд хурлуудын заалтыг биелүүлэхэд социалист уралдааныг гол хөшүүрэг болгон зохион байгуулж ирлээ.

Тайлангийн хугацаанд МҮЭ-ийн X их хурал, түүнд МАХН-ын Төв Хорооноос ирүүлсэн баярын бичиг, бүх ард түмний социалист уралдаан өрнүүлэх тухай МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн Төв Хорооны тогтоолыг биелүүлэх талаар бүгд ба тэргүүлэгчдийн хурлаар 13 удаа хэлэлцэж төлөвлөгөө зохион болзол гаргаж дүгнэх, туршлага ба үзүүлэх сургууль зохиох зэрэг арга хэмжээнүүд авлаа.

Социалист уралдааныг удирдаж зохион байгуулах ажлын арга барилыг сайжруулах талаар нэгдсэн ба төрөлжсөн зөвлөлтөөн семинарыг зохиож удирдах ажилтан, СХ-ийн бригадын ахлагчдыг оролцуулсан семинар зохиов.

Социалист уралдаан, СХ-ийн хөдөлгөөнийг хэрхэн зохион байгуулж өрнүүлж байгаа тухай Сэлэнгэ, Улаанбаатар хотын ХАА-н ҮЭ-ийн удирдах ажилтнуудтай бүсийн зөвлөлтөөн хийж туршлага солилцов.

Аймгийн аж ахуй, соёлын төлөвлөгөө болон уралдааны үүргийн биелэлтэнд аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны төлөвлөгөөний комисс, аймгийн сонин редакцитай хамтарсан үзлэг хийж тэргүүний турш-

лагыг нэвтрүүлэх, дутагдлыг засах арга хэмжээ авч байлаа.

Тайлангийн хугацаанд бүтээгдэхүүний чанар дээшлүүлэх асуудлаар үйлдвэр аж ахуйн газрын дарга, инженер, эдийн засагч, мастеруудын семинар хийлгэв.

Улсын төлөвлөгөө сурталчилж, уралдаанд үүрэг авахуулах ажлыг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаатай хамтран онд эхэнд тогтмол явуулдаг байв. 1973 онд уралдааныг үйлдвэр байгууллагын онцлогт тохируулан төрөл бүрийн хэлбэрээр өрнүүлж дүгнэх, уралдааны болон үүрд хадгалуулах туг, диплом, мөнгөн шагналын болзол гарган дүгнэж, шагналыг хэвлэл, зургагт хуудас, уралдааны ба хүндэт самбартавьг сурталчлан идэвхжүүлэх ажлыг зохиож ирлээ. Эдгээр арга хэмжээний үр дүнд уралдаан өрнүүлэх дэвшилт хэлбэрүүд гарч үйлдвэрлэлд нэвтрчээ.

Тайлангийн хугацаанд угтвар болон инженер техникийн ажилтны бүтээлч төлөвлөгөө зохиох, уралдааны гэрээ байгуулж ажиллах явдал шинээр гарч ирлээ.

1974 оны социалист уралдаанд аймгийн нийт ажиллагсдын 98,1 хувь нь үүрэг аваад ажиллаж байгаагаас гадна САА, ХАА-н нэгдэл, үйлдвэр аж ахуйн газар 36, тасаг, цех, бригад, ферм, хэсэг, салаа 369 хамрагджээ. Эдгээрээс Архустын ТАА зэрэг 6 газар угтвар төлөвлөгөөтэй, ХБҮ газар, Хүнсний үйлдвэр зэрэг 11 газар, 17 цех, тасаг, 682 хүн уралдааны гэрээтэй, 85 инженер техникч бүтээлч төлөвлөгөөтэй ажиллаж байна.

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар А.Орногвайн туршлагаар 3 бригад, хэсэг, нэхмэлчин Б.Гүнжиламын туршлагаар 3000 гаруй хүн 1-5 жилийн хувийн нарийн тооцоотой үүрэг аваад амжилттай биелүүлж байна.

Мөн саятан бригад 4, барилгын аж ахуйн тооцоот бригад 3, тэдгээрт 141 хүн хамрагдаж байгаа нь урьдах тайлангийн үеэс 9 дахингаар өсчээ. Уралдааны олон хэлбэр үйлдвэрлэлд нэвтрч хөдөлмөрчдийн улс төр, хөдөлмөрийн идэвх өрнөсний үрээр аж ахуй, соёлын төлөвлөгөө амжилттай биелэгдээ.

Аймгийн хэмжээгээр 1972 онд мал өсгөх улсын төлөвлөгөөг 100,3 хувиар биелүүлж, тариаланчдын шаргуу хөдөлмөрийн үрээр 1973 онд 11,2 сая шүүг үр тариа хураан авч аймгийн түүхэнд урьд үзэгдээгүй аварга амжилт гаргаж, улсдаа 149,3 мянган тонн үр тариа тушааж, төлөвлөгөөг 22,4-82,2 хувиар давуулав.

Үйлдвэрийн газрууд нийт бүтээгдэхүүний төлөвлөгөөг 13,6 сая төгрөгөөр давуулж бүх үйлдвэрүүд төлөвлөгөөгөө биелүүлж сайхан амжилт гаргав. Тайлангийн хугацаанд үйлдвэр аж ахуйн газруудын үндсэн фонд 11,8 хувиар өслөө. Тайлангийн хугацаанд аймгийн үйлдвэр аж ахуй, соёлын салбараас 100 гаруй ажилчин таван жилийн төлөвлөгөөг биелүүлээд байна.

Энэ амжилтаа бататган 1974 онд таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхээр 7 бай-

гууллага, 162 хүн МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн өмнө 28 байгууллага, 1346 хүн нэмэлт үүрэг аваад ажиллаж байна. Социалист уралдаанд түрүүлэгчдийн чуулга уулзалтаас гаргасан уриалгыг хүлээн аваад тус аймгийн хөдөлмөрчид урьд авсан үүрэг дээрээ төлөвлөгөөнөөс 921,1 мянган төгрөгийн бүтээгдэхүүн давуулж үйлдвэрлэх, төлөвлөгөөт алдагдлыг 120,0 мянган төгрөгөөр багасгаж, 385,1 мянган төгрөгийн нэмэгдэл ашиг олох, байгалийн баялаг, дотоод нөөц бололцоог ашиглах замаар 119,6 мянган төгрөгийн хуримтлал оруулахаар үүрэг аваад ажиллаж байна. Гэвч аймгийн ҮЭ-ийн болон улс, хороооллын байгууллагаас уралдаанд удирдах, зохиох байгуулах, дүгнэх ажлын арга барил намаас тавьж байгаа шаардлагын хэмжээнд хүртэл дээшилж чадаагүй байна. Ажилчид хамт олноороо уралдаанд үүрэг авахуулах ажилд цаг алдах, үүргийг эдийн засгийн үндэслэл тооцоотой авахуулах талаар тусалдаггүй, уралдааны үүргийг биелүүлэх график зохиож биелэлтийг хугацаанд нь чанартай дүгнэж, урамшуулах, дүнг нийтэд сурталчлах ажил дутагдалтай байна.

Энэ он гараад бүтэн улирал өнгөрч байхад аймгийн соёлын байгууллагууд болон Алтанбулаг суманд уралдаанд үүрэг аваагүй, авсан үүргээ мэдэхгүй ажилчин, малчин хүмүүс гарч байлаа. Малчдын уралдаанд үүрэг авахад нь тусалдаггүйгээс малын зүй бусын хорогдлыг багасгах, төл бойжуулах талаар МАХН-ын Төв Хороос гаргасан тогтоол шийдвэрээс доогуур үүрэг авсан явдал тус аймгийн нилээд нэгдэл гарч байлаа.

1974 оны уралдаанд Заамар сум мал өсгөх хөдөлгөөний төлөвлөгөөнөөс доогуур, Батсүмбэр, Лун, Алтанбулаг, Баянцагаан, Баяндэлгэр сумд малын өсөлтийг өнгөрсөн онд хүрсэн хэмжээнээс доогуур үүрэг авчээ.

Авто тээврийн XIII бааз, БУК, Ойн аж ахуй энэ оны уралдаанд үйлдвэрлэл эдийн засгийн чанарын үзүүлэлтийг өнгөрсөн оны хүрсэн хэмжээнээс доогуур авсан байна.

Уралдааны үүргийг үйлдвэрлэлийн даалгавар, төлөвлөгөөний биелэлтээр байр эзлүүлдэг дутагдал байна. Уралдааны явцад хуримтлагдсан туршлагыг нийтэд сурталчлах, нэвтрүүлэх, уралдаанд хошигнод ба дундчуудыг тэргүүний хүмүүсийн зэрэгт хүргэх болон үзлэг шалгалтаар илэрсэн дутагдлыг засах талаар албан байгууллагуудаас авч байгаа арга хэмжээ удаашраагүй байна. Социалист уралдааны шинэ хэлбэрийг нэвтрүүлэн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, нөөц бололцоог илрүүлэн ашиглах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний хүрээг өргөтгөж, соёл хөгжшүүрхай болгох талаар үйлдвэр аж ахуйн газрууд жигд анхаарч тодорхой ажил зохиохгүй байна.

*Товчлол нийтлэл

(Үргэлжлэл нь III нүүрт)



Аймгийн ҮЭ-ийн XVII бага хуралд ажил үйлсээрээ шалгарсан олон тэргүүний сайчууд төлөөлөгчөөр сонгогдон оролцсон юм. ЗУРАГ ДЭЭР: (Зүүн гараас) Баянчандмань сумын НААҮ-ний ангийн оёдолчин Х. Дашзэвэг, Чаргалантын САА-н хүний их эмч Д. Цэрэннадмид, мөн САА-н гахайчин Ж. Жамъян, Батсүмбэрийн САА-н ерөнхий инженер Л. Намжилдорж, Архустын сургууль комбинатын дежур У. Лхам, Борнуурын САА-н ногоочин Ц. Эрдэнэцоо, Архустын ТАА-н ногоочин Д. Рэнцэнханд

Н. ШАГДАРДАГВЫН ТАВЬСАН ИЛТГЭЛИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

Үргэлжлэл (Түрүүч нь III нүүрт)

сэн нь үр дүнд хүрч соёлч байгууллага айл өрхийн тоо олширсоор байна.

Одоо аймгийн хэмжээгээр гуанз, цайны газар 38, худалдааны цэг 102 ажиллаж байгаагийн дотор сар, улирал, жилийн төлөвлөгөөг тогтмол биедүүлж, хөдөлмөрчдөд хөтөн шуурхай үйлчилдэг Сэргэлэн сумын ХБ анги, байгууллагаараа СХ-ийн төлөө бригадын үүрэг аваад ажиллаж байгаа аймгийн аварга тогочо Даваажав эрхлэгчтэй гуанз зэрэг тэргүүний үйлчилгээтэй дэлгүүр гуанзны эгнээ өслөө.

Аймгийн УЭ-ийн зөвлөл, уурын зуухны кочегар, слесарь, механикчдын нэгдсэн зөвлөлийн жил дараалан хийлгэж тэргүүний ажиллагаатай хүмүүсийн туршлагыг дэлгэрүүлэх ажил зохиов.

Гэвч үйлчилгээний газруудад ариун цэвэр соёлжилт, цэвэрч боловсон шуурхай үйлчилгээ хэвшээгүй байна.

МҮЭ-ийн Х их хурал, олон нийтийн тэргүүний хянан шалгагчдын улсын зөвлөлгөөний шийдвэрийг биелүүлэхэд УЭ-ийн олон нийтийн хяналтын ажлыг бүрэн чиглүүлж үр нөлөөг нь дээшлүүлэх хэрэгтэй. Үйлчилгээний байгууллагын ажилд УЭ, Эрүүлийг хамгаалах байгууллагын хамтын үзлэг явуулж тэргүүний туршлагыг дэлгэрүүлэх, үйлчилгээний ажилд ажилчдыг сургаж далаажуулах идэвхжүүлэх ажлыг хэтийн төлөвлөгөөтэй зохиох, УЭ-ийн олон нийтийн ба аж байдал орон сууцны комиссын тэргүүний ажиллагаатай идэвхтнүүдийн ажлын туршлагыг харилцан солилуулах дэлгэрүүлэх ажлыг зохиох нь чухал.

Энэ талаар хэтийн ба жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулж батлахад УЭ олон түмнийг өргөн оролцуулж санал хүсэлтийг нь тусгах арга хэмжээг УЭ-ийн хороо, зөвлөлөөс зохиож байх хэрэгтэй.

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаатай хамтран жил тутам "хөдөлмөр хамгааллын үзлэг явуулж, гарсан туршлагыг нийтэд дэлгэрүүлэх, илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээг авч ирв.

Хөдөлмөр хамгааллын комисс 84, идэвхтэн 265 ажиллаж байна. Нийт үйлдвэр албан байгууллагууд аюулгүйн техникийн болон ариун цэврийн дүрэм, хөдөлмөрийн дотоод дүрэмтэй болсон бөгөөд хөдөлмөр хамгааллын кабинеттай байгууллагын тоо тайлангийн хугацаанд 20 гаруй хувиар өслөө.

Хөдөлмөр хамгааллын ажлыг сайжруулж материаллаг баазыг нь өргөтгөх талаар албан байгууллагуудаас анхаарч ажилласны дүнд хөдөлмөр хамгааллын төсөв 28,9 хувь өсч үйлдвэрлэлтэй холбогдсон ослын тоо 36,3 хувь, нас баралт 50 хувиар буурч Архуст, Эрдэнэ-сантын ТАА сүүлийн 3 жилд осол гэмтэлгүй ажиллав. Гэвч залуу ажилчид, түр ба улирлын чанартай ажилчдад аюулгүйн ажиллагааны арга барилын зааварчилгаа өгөлт тогтмолжсоогүй, удирдах ажилтан мэргэжилтнүүд ажилчдын хөдөлмөр хамгаалах хууль эрхийн мэдлэг хангалтгүй ялангуяа ХАА-н нэгдлийн малчид мэргэжилтнүүдийн хөдөлмөр хамгаалах муу байна.

Авто тээврийн XIII бааз 1973 онд хөдөлмөр хамгааллын зардалд 17146 төгрөг төсөвлөөд 33758 төгрөг зарцуулсан атлаа 1974 онд 6000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь хөдөлмөр хамгааллын ажилд ямарч тооцоо судалгаагүй хандлагын нэг баримт юм. Ажилчид, малчдын ажлын тусгай хувцас, нормын сүү бэлтгэлт олголтонд УЭ-ийн байгууллагаас тавих хяналт дутагдалтайгаас элдэв зөрчил гарч байна. Заамар, Баянжаргалан сумд малчид мэргэжилтнүүдийн хөдөлмөр хамгаалах муу анхаарч ажлын тусгай хувцас, Заамар суманд ажилчдад олгох сүүнээс 1972 онд 1620 литр, 1973 онд 963 литрийг дутуу олгож ажилчдыг хохироож байжээ.

Насанд хүрээгүй хүмүүс, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийг шөнийн ээлжинд гаргах, өдөрт илүү цагаар ажиллуулж ажлын хөдсгийг дутуу олгох зэрэг зөрчил Угтаалын тэжээлийн үйлдвэр, Зуунмод хотын худалдааны трестэд гарч байлаа.

Баянцагаан, Сэргэлэн, Эрдэнэ зэрэг нилээд сүм нэгдлүүд жирэмсэн эмэгтэйчүүдийн амрах

байрыг тохижуулж байнгын ажиллагаатай болгоогүй байна.

Олонхи нэгдэл, САА-д жирэмсэн, амаржсан эхчүүдийн амралтыг бүрэн эдлүүлэхгүй байна. Иймээс үйлдвэрлэлтэй холбогдсон осол, түр хүчээ алдалт тууштай буурч чадаагүйгээр барахгүй Бүрэн, Алтанбулаг, Заамар сум, Барилга угсралтын контор зэрэгт ослын актыг цаг тухайд нь тогтоож арга хэмжээ авахын оронд нуун дарагдуулж байжээ. БНМАУ-ын хөдөлмөрийн хууль, хөдөлмөр хамгааллын бусад хууль тогтоомжинд заасан эрхийг зөв хэрэгжүүлж, хөдөлмөр хамгааллын ажилд тавих төрийн болон олон нийтийн хяналтыг хүчтэй болгох хэрэгтэй. Үйлдвэр аж ахуйн газрын захирагчид ажилчдын ахуй хангамж, хөдөлмөрийн нөхцөлийг нарийн судалж жил бүрийн үйлдвэр сан хүүгийн төлөвлөгөөндөө тусган хөдөлмөр хамгааллын ажлыг хэтийн төлөвлөгөөтэй сайжруулах арга хэмжээг авбал зохино.

Үйлдвэрлэлийн нэгжид тавих хяналт шалгалтыг сайжруулах зорилгоор цаг үеийн кампанит ажлын үеэр үйлдвэрчний эвлэлийн түр бүлэг зохион байгуулах, хөдөлмөр хамгааллын олон нийтийн байцаагч, эргүүл пост ажиллуудаг журмыг хэвшил болгох, «Үйлдвэрлэлтэй холбогдсон осол зөрчилгүй ажиллаж хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх» гэсэн уриалга гаргаж сүүлийн 15 жил осол гэмтэлгүй ажилласан Москвагийн барилгын 26 дугаар трестийн бригадын дарга, ЗХУ-ын социалист хөдөлмөрийн баатар Н.А.Басовын туршлагаар ажиллаж осол зөрчилгүй, соёлч үйлчилгээтэй байгууллага, тасаг бригад, хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэх нь зүйтэй.

ГУРАВ. Нийгмийн даатгал, санхүүгийн талаар

Тайлангийн хугацаанд аймгийн УЭ-ийн зөвлөл нь санхүү нийгмийн даатгалын үйл ажиллагааг сайжруулан хөдөлмөрчдийн нийгмийн даатгалын үйлчилгээгээр хөнгөн шуурхай үйлчлэх, орлогын төлөвлөгөөнүүдийг жигд биелүүлэх төсөвт хөрөнгийг хэмнэлттэй зарцуулах, идэвхтэн нарын ажил хэргийн мэдлэгийг сайжруулахад гол анхаарлаа чиглүүлж ирлээ.

Аймгийн УЭ-ийн зөвлөлийн дэргэд эмнэлэг хөдөлмөр магадлах комисс, рашаан усны комиссыг ажиллуулан 800 гаруй ажилчин, албан хаагчдыг рашаан сувилалд явуулж, 638 хүний ажлын нөхцөлийг өөрчлүүлж, үйлдвэр аж ахуйн газруудаас хөнгөн ажлын акттай хүмүүсийн ажлыг хэрхэн зохицуулж байгаад хяналт тавьж зохицуулж байв. Тайлангийн хугацаанд нийгмийн даатгалын төсөв 40,7 хувь, түүнээс хүүхэд төрүүлсэн эхчүүдэд олгосон тэтгэмж 33,7 хувь, хүүхдийн арилгаа тэтгээлд олгосон тэтгэмж 19,4 хувиар өслөө. Мөн хугацаанд амралт сувилалд 5267 хүн, пионерийн зусланд 1242 пионер сурагч, амралт сувиллын цэцэрлэг, яслид 180 хүүхэд амарсан нь урьдах тайлангийн үеэс 8,5-1 дахин өслөө.

Алдар эх 220 хүн амралт сувилалд хөнгөлөлттэй зардлаар явж амарсан байна.

Түүнчлэн нийгмийн даатгалын орлогын төлөвлөгөөг 100,1—102,6 хувиар, гэгээрлийн шимтгэлийн орлогыг 101,6 хувь, УЭ-ийн гишүүдийн татварын орлогыг 104,0 хувиар биелүүлэв. Гэвч өвчлөлийг бууруулах талаар УЭ-ийн болон эрүүлийг хамгаалах байгууллагын зохиож байгаа ажлын уялдаа холбоо муу байгаагаас ажилчин албан хаагчдын түр хүчээ алдалт нэмэгдэж нэг тохиолдолд оногдох хоног дунджаар 14,2 хувиар өсчээ. Хүүхдийн халдварт өвчин ч буураагүй байна. Нийгмийн даатгалын шимтгэлийг хугацаанд нь оруулахгүй байгаагаас орлого саатаж байгаад дүгнэлт хийж ажиллах хэрэгтэй. Нийгмийн даатгалын хөрөнгөнөөс олгож байгаа тэтгэмжийн гол зөрчил нь ажилчин албан хаагчдын хөдөлмөрийн дэвтрийн хөтлөлт буруу, бүрэн бүрдэл болоогүйгээс шалтгаалж байгааг анхаарах хэрэгтэй. 1972 оноос эхлэн УЭ-ийн гишүүдийн татварыг цалингийн хүснэгтээр хурааж байгаа нь орлогыг хугацаанд нь оруулах татварыг бүрэн гүйцэд хурааж төвлөрсөн арга хэмжээг шуурхай санхүүжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

УЭ-ийн анхан шатны зөвлөл хороодоос

УЭ-ийн гишүүдийн татвар, шимтгэлийн орлого, орлогын байдлыг газар дээр нь тогтмол шалган хугацаанд нь оруулж, тэтгэмжийн олголтыг үнэн зөв шуурхай олгуулж байх хэрэгтэй.

ДӨРӨВ. УЭ-ийн зохион байгуулалтын удирдлагын арга барил, үр нөлөөг улам сайжруулах

Тайлангийн хугацаанд аймгийн УЭ-ийн зөвлөл, УЭ-ийн ардчилалыг бэхжүүлэн, эгнээг өргөтгөх болон МҮЭ-ийн Төв Зөвлөлийн IV, аймгийн УЭ-ийн зөвлөлийн II бүгд хурлын шийдвэрийг биелүүлэхэд ажлаа чиглүүлэн зохиож байна.

Тайлангийн хугацаанд аймгийн УЭ-ийн зөвлөлийн бүгд хурлыг 4 удаа, тэргүүлэгчдийн хурлыг сард 2 удаа хийж хамтын удирдлагын зарчмыг хэрэгжүүлж ирлээ.

Одоо УЭ-ийн зөвлөл, хороод 144, бүлэг 102, идэвхтэн 2228 ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд МҮЭ-ийн нийт гишүүний бат илэрхийлэх сольж УЭ-ийн байгууллагын аж ахуй, тоо бүртгэл, санхүүг цэгцэлсэн нь УЭ-ийн дотоод зохион байгуулалтын ажлыг сайжруулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болов.

УЭ-ийн гишүүдийн, бүх гишүүдийн хурлын ажил зэрэгч чанар үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хуралд хэлэлцэх асуудлыг жил, улирлаар төлөвлөн ханын хэвлэлд тавьж гишүүдэд урьдчилан мэдээлэх, илтгэл тавих байгууллага хүмүүст урьдчилан мэдэгдэж төлөвлөгөө гаргуулж бэлтгүүлэх, мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан комисс томилж шалгуулан, хуралд оруулах асуудлыг боловсруулах карт хөтлөн хэлэлцсэн асуудлыг давхардуулахгүй урьд гарсан заалтыг хариуцагч байгууллага, хүмүүсээр төлөвлөгөө гаргуулан хэрэгжүүлж биелэлтийг дараагийн хуралд мэдээлэх зэрэг аргыг хэрэглэж байна.

Тайлангийн хугацаанд хороо, зөвлөлдүүд бүх гишүүдийн хурлыг улиралд, төлөвлөгчдийн хурлыг хагас жилд 1 удаа, тэргүүлэгчдийн хурлыг сард 2 удаа хийж гишүүдийн 74 хувийг доошгүйг хамарч байжээ.

Аймгийн УЭ-ийн зөвлөл, дээд байгууллагын болон өөрийн тогтоол даалгаврын хугацаатай заалтад карт хөтөлж биелэлтийг тогтмол гаргаж байгаагийн дээр анхан шатны зөвлөл, хороод 1973 онд 218 тогтоол даалгаврын биелэлтийг гаргалаа.

Түүнчлэн шалгаж зааварлах ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилт тавьж зөвхөн 1973 онд анхан шатны зөвлөл, хороодыг 1—2 удаа шалган зааварласны дотор зарим зөвлөлийн ажиллагаанд хэлтсийн эрхлэгчдийн групп шалгалт, зааварлах ажилтны хамтарсан шалгалт явуулав.

УЭ-ийн идэвхтнийг саналаар нь ажиллуулах, тэдний ажил хэргийн мэдлэгийг өргөтгөх, тогтвор суурьшилтай ажиллуулж УЭ-ийн ажилд мэргэжлүүлэх, хороо зөвлөлийг мэргэжлийн хүмүүсээр хангах зорилгоор болзол зарлан, улирал, хагас бүтэн жилээр шалгаруулж байна.

Тайлангийн хугацаанд ажлаараа шалгарсан УЭ-ийн идэвхтэн 6 хүнийг гадаадад, 12 хүнийг дотоодын амралтанд амруулсан ба 2 хүнийг МҮЭ-ийн тэргүүний ажилтан тэмдэг, 142 хүнийг аймгийн зөвлөлийн шагналаар шагнаж урамшуулав.

Тайлангийн хугацаанд болсон нэг чухал үйл явдал бол ЗСБНХОУ-ын Курган мужийн УЭ-ийн байгууллагатай шууд холбоо тогтоосон явдал юм. Энэ нь ЗХУ-ын УЭ-ийн байгууллагын баялаг туршлагаас суралцах улам өргөн боломжоор хангагдаж байгаа хэрэг юм.

ЗХУ-ын УЭ-ийн байгууллагаас суралцах төлөвлөгөө боловсруулан УЭ-ийн анхан шатны зарим хороо зөвлөлийн хооронд шууд харилцаа тогтоож ажиллуулах асуудлыг судалж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Мөн гишүүдийн тоо бүртгэл, мэдээ тайланг хугацаанд нь гаргах явдал сайжирч бичиг хэргийн хөтлөлт, хадгалалт, хамгаалалт, батлах олголт зааврын дагуу явагдаж ирэв.

Тайлангийн хугацаанд аймгийн зөвлөл

Үргэлжлэл нь V нүүрт

Н. ШАГДАРДАГВЫН тавьсан илтгэлийн үргэлжлэл

Үргэлжлэл (Түрүүч II нүүрт)

МАХН-ын Төв Хорооны V, VIII, VII бүгд хурлын заалт, 1973 оны социалист уралдаанд түрүүлэгчдийн чуулга уулзалтаас гаргасан уриалга, бүх ард түмний социалист уралдааныг өрнүүлэх тухай тогтоолын заалтыг мөрдлөг болгон уралдааныг удирдан зохион байгуулах нь зүйтэй.

Улс хоршооллын салбарт бүтээгдэхүүний чанар, хөдөлмөрийн бүтээмжийг хэлбэрэлтгүй дээшлүүлэх, дотоод нөөц бололцоог дайчлан ашиглах, арвилан хэмнэлтийн журмыг тууштай нэвтрүүлэх явдлыг уралдааны гол үзүүлэлт болгож үйлдвэрлэлийг эдийн засаг, технологийн удирдлагаар хангаж ажиллах нь албан үйлдвэрийн болон ҮЭ-ийн удирдах ажилтан бүрийн үүрэг мөн.

Таван жилийн төлөвлөгөөг давуулан биелүүлэх, социалист уралдааны үүргийг ажилчин бүрээр авахуулж Батсүмбэрийн САА-н саальчин, БНМАУ-ын аварга малчин Ц.Хорлоо, мөн аж ахуйн ногоо бригадын дарга Ж.Пүрэв, Угтаалын САА-н трактор-комбайнч, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Г.Алтанхүү, Баян-өнжүүл сумын хоньчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, Ардын Их Хурлын депутат Б.Ажваа нарын ажлын амжилтыг давуулах талаар бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлэхийг тус бага хурлаас ҮЭ-ийн байгууллага, албан үйлдвэрийн газруудын чухал зорилт болгон тавьж байна.

Уралдааны дайчлагч, хүмүүжүүлэгч, бүтээл шинж чанарыг өндөржүүлэн хамт олныг хамарч оролцуулах, түүнийг удирдах зохион байгуулах ажлыг сайжруулан урьд хүрсэн амжилтыг бататган ахиулах эх сурвалж уралдааны дэвшилт хэлбэр, хувийн тооцоот үүрэг, инженер-техникийн ажилтны бүтээл болон угтвар төлөвлөгөө, уралдааны гэрээ, согоггүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх Саратовын систем, чанарын талон, мэргэжлийн уралдааныг үйлдвэрлэлийн онцлог-тоо тохируулан чанартай шуурхай өрнүүлэх нь ҮЭ-ийн болон үйлдвэр аж ахуйн газрын удирдах ажилтны үүрэг гэж үзэж байна.

СХ-ийн хөдөлгөөнийг Батсүмбэр, Жаргалантын САА, Хүнсний комбинат, Заамар зэрэг газрууд эрчимтэй өрнүүлж байгаагаар дээрх газруудын төлөвлөгөөт зорилтын 85,0-аас дээш хувийг зөвхөн СХ-ийн хамт олон бүтээж байна.

Батсүмбэрийн САА-н нам, захиргаа, ҮЭ-ийн байгууллага 1971 оноос эхлэн СХ-ийн хамт олны зөвлөлгөөний жил бүрийн 3 дугаар сарын 26-нд хийлгэж ажлы нь дүгнэдэг журамтай болов.

Энэ зөвлөлгөөнөөр нэг шинэ зүйлийг дэвшүүлж үр дүнг дараагийн зөвлөлгөөнд тайлагнаж байдгаас сүүлийн 2 жилд 600,0 мянгаас 3 сая гаруй төгрөгийн ашигтай ажиллажээ. Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөлмөрчдийг хөдөлмөр нийгмийн өмчинд хамтач үзэл санаагаар хандгах, социалист хууль ёсыг ёсчлон биелүүлдэг болгон хүмүүжүүлэхэд чиглүүлж, СХ-ийн хөдөлгөөнийг үйлдвэрлэл хөдөлмөр зохион байгуулалттай нягт уялдуулан өрнүүлэх зорилт тавьж байна.

ҮЭ-ийн болон албан байгууллагаас СХ-ийн хөдөлгөөнийг өрнүүлэх, удирдан зохион байгуулах иж бүрэн төлөвлөгөөтэй ажиллах нь зүйтэй.

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны төлөвлөгөөний комисстой хамтран шинийг санаачлагчдын нэгдсэн ба төрөлжсөн семинар зөвлөлгөөн хийлгэх зэрэг олон хэлбэрийн ажлыг зохиож ирсний зэрэгцээгээр нэвтрүүлэх туршлагын жагсаалтыг жил бүр гарган дүгнэж байлаа.

Өнгөрсөгч 2 жил гаруйн хугацаанд тэргүүн туршлага, оночтой санал 143 гарсны 109-ийг үйлдвэрлэлд нэвтрүүлж 106,8 мянган төгрөгийн ашиг улсад оруулсан нь урьдах тайлангийн үеэс үйлдвэрлэлд нэвтэрсэн туршлага 60,8 хувь, ашгийн хэмжээ 27,1 хувиар өсчээ. Гэвч оночтой саналыг бүртгэн авах, эрх хамгаалах талаар албан үйлдвэрийн газрууд муу дэмжиж байгаад дүгнэлт хийх хэрэгтэй.

Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн анхдугаар их хурлын шийдвэрийг биелүүлэх талаар тодорхой асуудал

төлөвлөн шинэ санаачилга, тэргүүн туршлага гаргагчдын хөдөлгөөнийг бүх нийтийн болгож эрчимтэй өрнүүлэх нь ҮЭ болон албан байгууллагуудын чухал зорилт мөн. Үйлдвэрлэлийн байнгын зөвлөлгөөний ажиллагаа тогтмолжин үйлдвэрлэлд нөлөөлөх үр нөлөө нь дээшлж ирлээ.

Аймгийн хэмжээгээр үйлдвэрлэлийн байнгын зөвлөлгөөн 17 ажиллаж 89 удаа зөвлөлгөөн хийж гаргасан шийдвэрийн биелэлтэнд тавих хяналтыг сайжруулснаар нэг га-гаас авсан ургац тайлангийн хугацаанд 56,3—81,0 хувь, фонд өгөмж САА, ТАА—д 10,2—56,0 хувь, барилга, худалдаа, зам ашиглалтын анги, НААҮ-ний газарт 0,8-98,0 хувь өсөв.

Үйлдвэрлэлийн байнгын зөвлөлгөөнийг тогтмол хийж, ҮЭ-ийн зөвлөлийн ажилтнуудыг оролцуулж байх, зөвлөлгөөнөөр үйлдвэрлэлийн үр ашиг, чанарын үзүүлэлтийг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой асуудлыг сайн бэлтгэлтэй хэлэлцүүлж гаргасан шийдвэрийг аж ахуйн байгууллагаар хэрэгжүүлэн дараагийн зөвлөлгөөнд тайлагнуулж байдаг журмыг хэвшил болгох, энэ талаар ҮЭ-ийн болон олон нийтийн хяналтыг сайжруулах нь чухал байна. Тайлангийн хугацаанд үйлдвэр аж ахуйн 23 газар хамтын гэрээтэй ажиллаж авсан үүргээс захиргааных 85,1—90,3 хувь, ҮЭ-ийн байгууллагынх 93,1—96,0 хувь нь биелэгджээ.

Гэвч зарим үйлдвэрийн захиргаа, ҮЭ-ийн байгууллагаас хамтын гэрээнд авч байгаа үүргийн чанар, тооцоо, эдийн засгийн үндэслэл муу, түүний биелэлтийг хугацаанд нь дүгнэж тайлагнахгүй ардчилалыг зөрчиж байгаа дутагдлыг арилгах хэрэгтэй.

Хамтын гэрээг үйлдвэрлэлийн программтай уялдуулан 3-5 жилээр байгуулж орон сууц, нийгэм соёлын үйлчилгээний арга хэмжээ, хөрөнгө оруулалттай холбогдсон ажлыг ялангуяа САА, ТАА-д туршиж үзэх нь зүйтэй юм.

Тайлангийн хугацаанд үйлдвэр аж ахуйн 38 байгууллагын төлөвлөгөөний төслийг 200 гаруй газарт ажилчдын хурал, зөвлөлгөөнөөр хэлэлцүүлж 310 гаруй санал гарсны 194-ийг нь төлөвлөгөөнд тусгаж арга хэмжээ авлаа.

Үйлдвэрлэлийн төлөвлөгөөг орон нутгийн онцлогт зохицуулан зохиох, аж ахуйн дотоод нөөцийг илрүүлж төлөвлөгөөнд тусгах ажил, хөдөлмөр нийгмийн өмчинд үнэнч хандах үзлээр хүмүүжүүлэх, үйлдвэрлэлийг удирдах, төлөвлөхөд ажилчин, албан хаагчдыг улам өргөн оролцуулах ажил зохиох хэрэгтэй. ҮЭ-ийн үйлдвэр олон түмний ажлын нэг чухал хэсэг нь хөдөлмөр цалин хөлс, нормчлолын асуудлыг байнга боловсронгуй болгох, түүнд тавих хяналтыг тогтмолжуулах явдал юм. Аймгийн эдийн засгийн зөвлөл, эдийн засгийн шинжилгээний олон нийтийн товчоотой хамтран нилээд газруудад хөдөлмөрийн цаг ашиглалт, хөдөлмөрийн нормчлол, нормын биелэлтэнд шалгалт хийж нормчлолын талаар сурталчлан туслах ажил зохиов.

Ажлын норм, цалин хөлс, урамшууллын системийг боловсронгуй болгох түүнийг зөв мөрдүүлэх талаар тавих хяналтыг хороо зөвлөлдүүд өндөржүүлэх, энэ ажилд комисс идэвхтний хүчийг зохион байгуулж бие даасан ажил зохиох хэрэгтэй.

Тайлангийн хугацаанд олон нийтийн шүүх 36 ажиллаж, өөрсдийн санаачилгаар 108 байгууллага, ажилчдын санаачилгаар 396 хэрэг шийдвэрлэсний гадна хөдөлмөр эрхийн холбогдолтой хууль зарлиг, тогтоол заавар сурталчлах, ажилчдад дугуйлангаар хичээл зааж шалгалт авах зэрэг ажлууд зохиолоо. Хөдөлмөрчдөд хууль эрхийн мэдлэг, хүмүүжил олгох ажилд олон нийтийн шүүхийн ролийг дээшлүүлж түүний бие даасан ажиллагааг нь өндөржүүлэх явдалд мэргэжлийн удирдлага тусалцааг аймгийн зөвлөл, хуулийн байгууллагаас үзүүлж байвал зохино.

ХОЁР. Хөдөлмөрчдийн материаллаг аж байдлыг дээшлүүлж, хөдөлмөрийн хамт олныг хүмүүжүүлэх нь ҮЭ-ийн соёл олон түмний ажлын гол зорилт мөн.

Тайлангийн хугацаанд аймгийн ҮЭ-ийн зөвлөл ажилчин албан хаагчдын улс төр,

ерөнхий боловсрол, үйлдвэрлэл техникийн мэргэжлийг системтэй дээшлүүлэхэд соёл олон түмний ажлаа чиглүүлэн зохиож ирлээ.

ҮЭ-ийн гэгээрлийн системийг 1972—1974 оны хичээлийн жилээс СХ-ийн сургууль болгон өөрчилж зохион байгуулан, энэ хугацаанд 93 сургуульд 5826 ажилчин албан хаагчид хамрагдан суралцлаа. Мөн хугацаанд 859 хүн шинээр мэргэжил эзэмшиж, 978 хүн мэргэжлийн зэргээ ахиулж, 1754 хүн ерөнхий боловсролоор шат ахив.

Тайлангийн хугацаанд бага, дунд боловсролтой ажилчдын тоо 9,3—12,5 хувь, мэргэжил эзэмшсэн ажилчинд 10,1 хувиар өссөн нь ҮЭ-ийн дугуйлан сургуулийн үр нөлөө дээшилсний баримт юм. Тэргүүний ажиллагаатай клуб шалгаруулах уралдаан зарлан сайн дурын уран сайханчдын үзлэг явуулж 8 мянга гаруй уран сайханчид хамруулан, Баянчандмань, Жаргалантын САА-н ажилчдын клубүүд шалгарч байр эзлэв.

Ажилчны клуб улаан булангаас хөдөлмөрчдийн дунд зохиож байгаа соёл-олон түмний ажил сайжирч үр нөлөө нь дээшилж байна. Тайлангийн хугацаанд ажилчны клубүүдийн материаллаг бааз бэхжиж түүнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 13,2 хувиар өсөв. Сайн дурын үүсгэл санаачилгаар Баянчандманьд 8 мянга гаруй тамирчдыг хамарч бэлтгэл зохион байгуулалттай явуулсны дунд бүсэд II, улсад VII байр эзэлж спортын мастер I, улсын зэрэгтэй тамирчин 103-ыг төрүүлж биеийн тамир спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэхэд ихээхэн ач холбогдолтой боллоо.

Тайлангийн хугацаанд ҮЭ-ийн соёл олон түмний нийт идэвхтэн байгууллага идэвхтнүүдийн ажлыг шалгаж зааварлах, семинар зөвлөлгөөн хийлгэх зэргээр ажиллаж ирсний үр дүнд Борнуур, Хүнсний комбинат, 10 жилийн дунд сургууль, Заамар сумын хороо зөвлөлийн соёл олон түмний комисс идэвхтнүүдийн ажиллагаа сайжирлаа.

Гэвч ҮЭ-ийн анхан шатны байгууллагууд соёл олон түмний ажлаа цаг үеийн зорилттой холбож амьдралын нарийн судалгаа дүгнэлтэд тулгуурлан зохиох явдал хангалтгүй байна. Иймээс ҮЭ-ийн соёл олон түмний ажлын ахиц дэвшилттэй сайн арга хэлбэрүүдийг бэхжүүлж МАХН-ын XVI их хурал, ҮЭ-ийн Х их хуралд МАХН-ын Төв Хорооноос ирүүлсэн баарын бичигт заасан заалтыг удирдлага болгож соёл олон түмний ажлын үр нөлөөг сайжруулах нь тус аймгийн ҮЭ-ийн байгууллагуудын зорилт болж байна. ҮЭ-ийн суртал нэвтрүүлэгч СХ-ийн сургуулийн чанарыг эрс дээшлүүлэх, ҮЭ-ийн бүх шатны байгууллагууд лекц, онолын хурал, маргаан, асуулт, хариулт, үзүүлэлт болон бусад хэлбэрийн сурталчилгааг явуулахдаа үйлдвэр аж ахуйн газрын онцлог, хөдөлмөрчдийн эрэлт шаардлагад тохируулан аппарат хэрэгслийн тусламжтайгаар явуулж байх нь зүйтэй.

Хөдөлмөрчдийн байнга өсөн нэмэгдэж байгаа аж байдал соёлын хэмжээг улам сайжруулахад ахуй соёлын үйлчилгээг хөнгөн шуурхай болгон ҮЭ-ийн олон нийтийн хяналтын комисс, аж байдал, орон сууцны комиссын ажлын үр нөлөөг дээшлүүлэх явдал чухал юм.

Тайлангийн хугацаанд ҮЭ-ийн олон нийтийн хяналтын комисс 23, аж байдал орон сууцны комисс 56, идэвхтэн 228 ажиллаж, 540 удаа үзлэг хийж, 420 дутагдал зөрчил илрүүлэн засчээ.

Мөн аймгийн төвийн бүх үйлдвэр, үйлчилгээний газруудад соёлч байгууллагын үзлэг явуулж I дүгээр ясли, сүрьеэ диспансер зэрэг 5 газарт СОЁЛЧ БАЙГУУЛЛАГЫН гэрчилгээ олгон, бүх албан газруудын ариун цэврийн ажилтан, аж ахуйн хүмүүсийг оролцуулсан зөвлөлгөөн хийлгэ-

(Үргэлжлэл нь IV нүүрт)

Н. ШАГДАРДАГВЫН тавьсан илтгэлийн төгсгөл

Төгсгөл. (Түрүүч нь IV нүүрт)

130 гаруй өргөдөл хүлээн авч хугацаанд нь барагдууллаа.

Аймгийн УЗ-ийн байгууллага боловсон хүчнээр улам бэхжиж, зохион байгуулалт, үйлдвэрлэл олон түмэн, соёл олон түмний ажлын үр нөлөө дээшилж нийгмийн даатгалын үйлчилгээний хүрээ өргөсөж УЗ-ийн ардчилсан төвлөн удирдах зарчмыг биелүүлд ирэв. Гэвч УЗ-ийн зохион байгуулалт олон түмний ажил, улсын төлөвлөгөө биелүүлэхэд нөлөөлөх түүний дайчин чадвар хангалтгүй байна.

Сум-нэгдлийн олонх УЗ-ийн зөвлөл соёл боловсрол, эрүүдлийг хамгаалах байгууллагын дэргэдэх зарим хороо бүлгүүд хурлаа тасалж байна. Иймээс ч тэндэхийн ажилчин албан хаагчдын дунд хөдөлмөрийн цаг таслах, гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчил гаргах, хөдөлмөрийн шинэ хууль, зарлигийн заалт зөрчих явдал гарч байна.

Төлөвлөгөөт зорилт, уралдааны үүргийг гол анхаарч байгаа нэрийдлээр дотоод ажлаа орхигдуулах дутагдал Угтаа, Баянцогт сумдын УЗ-ийн зөвлөлийн ажиллагаанд оршиж байна. УЗ-ийн ажилд идэвхтнийг сургаж тогтвортой ажиллуулах олон нийтийн үүсгэл санаачилгаар ажиллах хөдөлгөөнийг дэмжиж өрнүүлэх, ер нь идэвхтэн УЗ-ийн гол хүч гэдгийг зөв үнэлэхгүй явдал Баян, Баянцагаан, Дэлгэрхаан, Лүн, Мөнгөнморьт сумдын зөвлөлийн ажиллагаанд байна.

Эдгээр дутагдалд дүгнэлт хийж ажлаа сайжруулах нь УЗ-ийн зөвлөл хороодын чухал зорилт мөн. Ялангуяа олон нийтийн үүсгэл санаачилгаар ажиллах хөдөлгөөнийг өргөн өрнүүлж идэвхтнүүдийг УЗ-ийн олон талт ажилд сургаж дадлагажуулахад хороо зөвлөл гол анхаарлаа чиглүүлэл зохино. УЗ-ийн эгнээг өргөтгөх, УЗ-ийн хороо бүлгүүдийг үйлдвэрлэл ба орон нутгийн чиглэлээр зөв байрлуулж байгуулах тэдний дотоод ажлыг сайжруулж, түшиглэсэн байгууллагын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх тэмцэлд нөлөөлөх үр нөлөөг нь дээшлүүлэх, үүний тулд жилийн төлөвлөгөөт ажлын 70 хувийг доошгүй хувийг гүйцэтгэлийн шалгалт, үйлдвэрлэлд чиглүүлж ажилуулана.

Үйлдвэрлэлийн нэгч, бригад, ферм, тасаг, цехэд УЗ-ийн салбар хороо бүлгийг

байгуулж гишүүд ажилчдын хурлын ролийг өндөржүүлэн үйлдвэрлэлийн гол гогцоо асуудлыг хэлэлцүүлж ажил хэрэгч шүүмжлэлийг өрнүүлж, түүний мөрөөр шуурхай, тодорхой ажил зохиож дүнг хамт олонд нь эргүүлэн тайлагнаж байдаг журмыг хэвшил болгох хэрэгтэй.

УЗ-ийн зөвлөл хороодын дарга нарын нэгдсэн ба идэвхтний төрөлжсөн семинарыг жилд 1 удаа хийж анхан шатны байгууллагуудын ажиллагаанд гарч байгаа тэргүүн туршлагыг харилцан солилцуулж байхын хамт аймгийн төв, томоохон хороо зөвлөлдүүдийн дэргэд 1974—1975 оноос УЗ-ийн идэвхтний оройн сургууль байгуулж хичээллүүлнэ.

БНМАУ-ын хөдөлмөрийн хууль, МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал, Ардын Их Хурлын чуулганы шийдвэрийг ажилчин албан хаагчдад гүнзгий судлуулж гэмт хэрэг зөрчилгүй хамт олон болж хөдөлмөрийн сахилга батыг тууштай бэхжүүлж ажилчин албан хаагч УЗ-ийн гишүүн бүрийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх хэрэгтэй.

НӨХӨД ӨӨ!

Тус аймгийн хөдөлмөрд аймагийн Намын XVI, УЗ-ийн XVII бага хурал болон түүхт ойнууд угтсан бүх ард түмний социалист уралдааны жил 1974 оны эхний гараанд сайхан амжилт олсон ба олсоор байна.

Аймгийн хэмжээгээр 6 дугаар сарын 2-ны байдлаар төлөвлөх зохих малын 81,4 хувь төвлөж гарсан төлийн 93,3 хувийг бойжуулж төлийн хорогдлыг өнгөрсөн оны мөн үеийнхээс 40,6 хувь бууруулан 1974 оны төл бойжуулах улсын төлөвлөгөөг урьдчилсан байдлаар 101,2 хувиар биелүүлж аймгуудын дотор 2 дугаар байранд явж байна. Хаврын тариалалтыг 102,0 хувиар биелүүлэв. Аймгийн нам, УЗ-ийн ээлжит бага хурлуудыг угтсан хөдөлмөрийн өдрүүдэд социалист хөдөлмөрийн Зам ашиглалтын ангийн хамт олон таван жилийн төлөвлөгөөгөө 1 жил 9 сарын өмнө 103,3 хувиар биелүүлж аймгийн үйлдвэр аж ахуйн газруудаас шалгарч таван жилийн анхны гавшгайч хамт олон боллоо.

Хүнсний комбинат эхний хагас жилийн төлөвлөгөөг төрөл дээр нь 6,1 хувиар, авто тээврийн XIII бааз ачаа ба зорчигч эргэлтийн эхний хагас жилийн төлөвлөгөөг 100,6—102,0, бараа борлолтын төлөвлөгөөг 103 хувиар биелүүлсэн амжилтаар тус ба-

га хурлаа угтсаныг тэмдэглэхэд бахархалтай байна. Ардын боловсрол, соёл эрүүдлийг хамгаалах байгууллагын эхний хагас жилийн төлөвлөгөөт зорилт уралдаанд авсан үүрэг амжилттай биелэгдэж байна.

Аймгийн аж ахуй соёлыг хөгжүүлэх шинэ таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жил хагасын байдал, их ойнууд угтсан ажлын явцад дүгнэлт хийж ажиллавал зохих зүйл нилээд байгааг бага хурлын төлөөлөгчдийн анхааралд тавьж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж аймгийн УЗ-ийн зөвлөл үзэж байна.

Аймгийн хэмжээгээр том малын зүй бусын хорогдол урьд оны мөн үеийнхээс багассан хэдий боловч оны эхэнд байсан малын 0,8 хувь буюу 11,8 мал хорогдсон нь цаг улирлын зохистой байгаа нөхцөлд харьцангуй их байна.

Гүү, үнээний хээлтүүлэг, ХАА-н барилга, бодын хөөвөр, хялгас ямааны ноолуурын төлөвлөгөөний биелэлт удаашралтай байна.

Үйлдвэр аж ахуйн зарим газруудад бүтээгдэхүүний нэр төрлийн төлөвлөгөөний биелэлт тасалдаж чанарын үзүүлэлт доголдож явна. Аймгийн хэмжээгээр V таван жилийн төлөвлөгөөгөөр тавигдсан мал өсгөх болон газар тариалан, худалдаа бэлтгэлийн төлөвлөгөөт зорилтуудаас эхний 3 жилд биелүүлж чадаагүй зүйлийн нөхөн гүйцэтгэх хариуцлагатай үүрэг тавигдаж байна.

НӨХӨД ӨӨ!

Саяхан болж өнгөрсөн МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал, Ардын Их Хурлын ээлжит чуулганы шийдвэр, Намын Төв Хорооны бүгд хурал дээр МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга н. Ю. Цэдэнбалын хэлсэн үгийг гүнзгий судлуулж, эрчимтэй хэрэгжүүлэх явдал УЗ-ийн байгууллагуудын нэн тэргүүний зорилт болж байна. V таван жилийн төлөвлөгөөг давуулан биелүүлж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд УЗ-ийн анхан шатны байгууллагуудын үйл ажиллагааг нам, улс, хоршооллын байгууллагын ажилтай нягт уялдуулан социалист уралдааныг өрнүүлж хөдөлмөрийн хамт олныг идэвхжүүлэн хүмүүжүүлэх замаар УЗ-ийн анхан шатны байгууллагын ажлыг жигд сайжруулж төлөвлөгөөт зорилтыг чанарын өндөр үзүүлэлтэйгээр давуулан биелүүлэхэд бүх авьяас мэдлэг, хүч чадлаа шавхан дайчилж ажиллацгаая.



ТОГЛООМ БЭЛЭГЛЭВ

Хүүхдийн төлөө фондын төв комиссын дарга А. И. Цэдэнбал-Филатова энэ онд хүүхдийн төлөө фондоо оруулах "хуримтлалыг сайн зохион байгуулсан аймгийн хүүхдийн төлөө фондын комисст цэцэрлэгийн комплект тоглоом бэлэглэснийг хүүхдийн төлөө фондын Төв комиссын гишүүн Дашдэндэв, аймгийн хүүхдийн төлөө фондын комиссын дарга П. Жанчивт саяхан хүлээлгэн өглөө.

Одоогийн байдлаар аймгийн дүнгээр хүүхдийн төлөө фондоо 200 гаруй минган төгрөг оруулаад байгаа нь өнгөрсөн оныхоос 40 гаруй хувь илүү байна. Энэ бэлэглэсэн тоглоомоор аймгийн ХЗЭ-ийн хороон дээр үзэсгэлэн байгуулсныг Намын хорооны товчоо, АДХ-ын гүй-

цэтгэх захиргааны гишүүд, мөн нийт сумын ХЗЭ-ийн үүр, хороодын нарийн бичгийн дарга, эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга нар үзэж сонирхлоо.

Энэ бэлэглэсэн тоглоомонд төрөл бүрийн хөгжим, хүүхэлдэй, сав суулга, хөдөлмөрийн багаж, тооллын хэрэгсэл, жин хэмжүүр, эвлүүлж бүтээх зүйл, бөмбөг, өөрөө явагч машин, индүү, пластик, угаалгын хэрэгсэл зэрэг бага насны хүүхдүүдэд хөдөлмөрийн зохих дадлага олгоход зориулагдсан 200 гаруй нирхэг, 100 рублийн үнэ бүхий зүйл байгаа юм.

Уг тоглоомыг аймгийн хүүхдийн төлөө фондын комиссоос цэцэрлэгүүдийн дунд уралдаан зарлаж БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойгоор шалгаруулан шагнах юм.

Л. ГУНГААБУУ

ТУРШЛАГАТАЙ ИДЭВХТЭН

Борнуурын САА-н УЗ-ийн зөвлөлийн хяналтын комиссын даргаар САА-н ерөнхий инженер Б. Сономжамц ажилладаг.

Сономжамц УЗ-ийн идэвхтний ажлыг 15 жил тасралтгүй хийж байгаагийн сүүлийн 3 жилд нь УЗ-ийн зөвлөлийн хяналтын комиссын даргаар ажиллаж байна.

Комиссын хурлыг улиралд тогтмол хийж ажил төрлийн оновчтой асуудал хэлэлцэж, түүнийг хэрэгжүүлж мөрөөр ажилладаг юм.

Урьд онд сумын төвийн худалдаа бэлтгэлийн ангийн үйлчилгээнд, их эмчийн салбар, ясли, хаврын тариалалтын үеийн хөдөлмөр хамгааллын ажилд хийсэн шалгалтын дүнгийн тухай хэлэлцэж протокол гарган, үйлчилгээний ажил хангалтгүй байсан ХБ ангид шаардах хуудас өгч ажилласан нь үр дүнд хүрч үйлчилгээний ажил сайжирсны гадна жижүүрийн дэлгүүр ажиллуулсан нь хөдөлмөрдийн талархлыг хүлээжээ.

Тус комисс ажлын төлөвлөгөөг жил улирлаар хийж гишүүдийн хурлаар баталж ажилладаг юм.

Төлөвлөгөөний биелэлтийг жил улирлын эцэст гарган хурлын өмнө гишүүдэд мэдэгддэгийн гадна комиссын гишүүн бүрийг зохиосон ажлын дэвтэртэй болгож түүнийг сард нэг удаа үзэж зөвлөлтөө өгдөг байна.

Комиссын гишүүдэд сумын төвийн гол гол байгууллагуудыг хуваарилан өгч байнгын хяналт тавиулж байгаагийн гадна хамтарсан үзлэгийн үе үе явуулдаг байна.

1973 онд ХБ анги, хүний их эмчийн салбар, ясли, цэцэрлэг, авто ба ХАА-н гарааш, холбооны салбарын үйлчилгээний ажилд групп шалгалт хийж зохих арга хэмжээ авчээ.

1974 онд цэцэрлэгийн барилга он удаан жил болж хүүхэд байрлах бололцоогүй болсонд шалгалт хийж саналаа УЗ-ийн зөвлөлд танилцуул-

жээ. Б. Сономжамц ЗХУ-ын УЗ-ийн туршлагаар комиссын шалгалт графикийг жилийн эхэнд гаргаж УЗ-ийн зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар батлуулж түүнийг мөрдөн ажилладаг нь хяналт шалгалтын ажлыг байнга үр дүнд хүргэж байна.

Хаврын тариалалт, намрын тариа ногоо хураалтын өмнө ажилчин албан хаагчдын орон сууц ахуй хангамж, үйлчилгээг шалгаж хөдөлмөр хамгаалал, аюулгүйн талаар хичээл семинар хийнээр тус САА-д сүүлийн 5 жилд осол аюул гараагүй байна. Б. Сономжамц зөвхөн энэ комиссын ажлыг сайн мийгээд зогсохгүй УЗ-ийн олон талт ажилд идэвхтэй оролцдог хүн. Энэ онд ажилчны клубт зургагт радиотангийн антена хийж ашигдалдад оруулжээ. Мөн ЗХУ-ын Украины Донийн услагын системийг нэвтрүүлэх, ногоон солом хураах, хонь угаах, хяргах нэгдсэн цахилгаан агрегат хийх гэж байна.

Д. ДУЛАМЖАВ

ХАМТАРСАН ЗӨВЛӨЛГӨӨН БОЛОВ

Саяхан аймгийн ХЗЭ-ийн хороо, эмэгтэйчүүдийн зөвлөлөөс «Ахуйд соёл нэвтрүүлэх» ажлын эрчимжүүлэх асуудлаар хамтарсан зөвлөлгөөн хийлээ. Зөвлөлгөөнд бүх сум, САА, үйлдвэр, албан газруудын ХЗЭ-ийн хүүр хороодын дарга, эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга нар оролцдоо.

Зөвлөлгөөнийг аймгийн ХЗЭ-ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга П. Жанчив нээж ХЗЭ-ийн хорооны ажилтан Д. Дэмбэрэл, Ардын боловсролын хэлтсийн дарга Т. Гавал, Баянцогтын САА-н ХЗЭ-ийн хорооны нарийн бичгийн дарга Л. Мамаажав, Эрүүлийг хамгаалах газрын дарга Б. Галсан-

дорж, АДХ-ын гүйцэтгэх захиргааны соёлын хэлтсийн мэргэжилтэн Н. Содномхүү, Жаргалантын САА-н эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Л. Насанхүү, Эрдэнэсант сумын ХЗЭ-ийн үүрийн дарга Ц. Ерөөл нар сум орон нутагтаа ахуйн соёлжилтыг дээшлүүлэх талаар зохиож байгаа ажлын туршлага, саналаа ярилаа.

Уг зөвлөлгөөнд аймгийн Намын хорооны үзэл суртлын хэлтсийн эрхлэгч Я. Дамдинсүрэн оролцож үг хэлэв.

Зөвлөлгөөнөөс нийт ХЗЭ-ийн анхан шатны байгууллагууд, эмэгтэйчүүдийн зөвлөлдөд зөвлөмж гаргав.

Л. ХЭНЧ-ЯАХАВ

ГЯЛАЙЛАА ХҮҮ МИНЬ

(СУРВАЛЖЛАГА)

—Энэ л танай охинд таарна даа гээд худалдагч бүсгүй уриалагхан нь аргагүй бичхэн ачид нь бо-
таник тааруулан өгөхөд эмээ ихэд байрлан гялайлаа хүү минь, би өөрөө авсан бол багадауулчих байж шүү гэсээр гарч одлоо.

Энэ явдал анхаарал татаж худалдагч бүсгүйтэй уулзан ярилцвал:

—Би 2 дугаар улирлынхаа бараа борлуулалтын төлөвлөгөөг нэг сарын өмнө 136 хувиар давуулан биелүүлдэг 6 дугаар сард 40 мянган төгрөгийн гүйлгээ хийх зорилттой ажиллаж байна.

Би лагуу болон ханын

шкафт метрийн бараа, бэлэн хувцасны өнгө хар, шуулан үзэмжтэй байрлуулж, үнэ болон хэмжээг нь тодорхой бичиж хадаг, хөдөлмөрчдөд бараагаа сурталчлах ажлаас үйлчилгээгээ эхэлдэг. Юуны өмнө хайч, метр, боодлын цаасыг гарын дор ойр байлгах зэрэг хувийн бэлтгэлээ сайн хангадаг.

Дэлгүүр дотроо цэвэр цэмцгэр, гэрэл гэгээтэй, саруулхан, халуу дүүгэж байвал хөдөлмөрчид тавтай тухтай үйлчлүүлдэг юм.

Худалдан авагчидтай эелдэг зөөлөн харьцаж, ямар бараа авах гэж байгааг

мэдмэгц, уул барааны материалын чанар байдал, яаж угаах, индүүдэхээс эхлэн ямар насны хүнд тохирох, аль улиралд хэрэглэх зэргийг нь хэлж өгдөг. Худалдагч хүн ямар насны хүнд ямар хэмжээний хувцас тохирох дундаж хэмжээг мэдэж байх хэрэгтэй.

Ер нь хүнийг хүлээлгэлгүй түргэн үйлчлэхийг л зорьдог.

Ингэж үйлчилэхэд бараа борлогдох нь түргэн юм шиг санагддаг гэж Эрдэнэ сумын барааны дэлгүүрийн бэлэн хувцасны тасгийн худалдагч Чавганц ярилаа.

Д. ОТГОН

МОРИНД ЭРЭМГИЙ ОХИН

ТЭМДЭГЛЭЛ

Сумын төвийн биений тампын талбайд гоёлын хувцасаа өмссөн хүмүүс хуран цугларсан байв.

Эмнэг булгуулах тэмцээнд 16 настай охин оролцож гэнэ.

Тэгэхдээ нас гүйцсэн эсгэл азарга унах гэнэ шүү гэсэн нэгэн яриа олны дотор амнаас ам дамжин тархав.

Удалгүй тэмцээн эхлэх болж адуун сүрэг багшран дөхсөөр ирэв.

Урт уурга суналзуулсан адуучин залуучууд уургач морьдоо барин унацгаалаа.

Хамгийн түрүүнд өвдгөө хүрсэн дэлтэй хар азаргыг уургалан барьж эмээлдэхэд бага хирнээ бялдархуу биетэй хүү мордох болов.

Энэ бол Баянцогт сум-

САА-н 8 жилийн дунд сургуулийн 7 дугаар ангийн сурагч Ганбаатар ажээ. Тэрээр булгуулагчид сайхан тогтож олны талархал хүлээв.

Дараа нь бас нэгэн хар азаргыг уургалан бариваас араатан амьтан санагдуулам догшин ажээ. Олны дотроос, дээлийн хормойг эргүүлэн бүсэндээ хавчуулсан жижигхэн охин эмээл барьсаар азарганы дэргэд очив.

Тэр охины нүд цогтойёо гялалзан нээмсэглэн байхыг ажвал айж эмээсэн шинж огт алга. Харваас сэргэлэн охин байлаа. Цорровдолт, чихдэлтэнд биес хураан ханаран зогсож байгаа хангал азарганы нуруун дээр Гууны фермын үхэрчин Рэнчинханд үсрэн гарлаа. Онгон сала-

хинаас өөр юм биендээ хүргээгүй хангал азарганы толгой руу охин «Чамайгдаа» гэсэн шиг ширтэн харж, хэвгийхэн суугаад тавь гэсэн дохио өгөхөд аргамаг хөлөг дүүлэн хөдөлснөө ёстой л «дээшээ» тэнгэрийн од тоолоноооо газрын үндэс тоолоноо булгив. Охин азарганы хүчт булгалтанд ажрахгүй тогтож, харахын сайнаар харж булгуулсаар холдон одоход хүмүүс алга ижижигүүлэн ташиж, ам амандаа шагшин магтаж, зарим нь «Угүй бас их айлаа» гэж түгжсэн амьсгалаа гадагш гаргаж байлаа. Хангал азарга хичнээн ч махран булигаад охиныг унагаж чадаагүй дээ уурссан мэт амьсгалаа дан зогсоов.

Ийнхүү адуунд эрэмгий авхаалж тэвчээртэй нэгэн охин эмнэг азаргыг эрхэн дээ оруулсан юм. Ухаан сэргэлэн, хараа хурц, булчин чанга шанташгүй зоригтой ийм охинд, хөвгүүд эх орны ямар ч даалгаврыг нэр төртэй биелүүлж чаднаа гэсэн бахархлын сэтгэгдэл төрж билээ.

Д. ТОВУУ



Аймгийн Дүрслэх урлагийн салбарын наалагчийн Базаржав 1974 оны бүх ард түмний социалист уралдааны жилийн төлөвлөгөө болон уралдаанд авсан үүргээ амжилттай биелүүлж хамт олноо хошуучилж явна.

Тэрээр энэ оны эхний хагас жилийн төлөвлөгөөг 1 сарын өмнө биелүүлдэг.

ЗУРАГ ДЭЭР:

Базаржав ажил дээрээ.

Л. ДАМДИНДОРЖ-ийн авсан гэрэл зураг



ЗХУ-ын малчдын туршлага

Бэлчээрийг нүүдлээр ашиглах арга

ЗХУ-ын өмнөт хэсэг Буриад, Тува АССР зэрэг тал хээрийн бэлчээртэй нутгуудад жилийн дөрвөн улиралд малд тохирох бэлчээрээ сонгон авч бэлчээрийн хооронд урт богино нүүдэл, хөнгөн маягийн зөөвөр хийхээс гадна нэг нутгийн бэлчээрээ тодорхой системтэй ашигладаг байна.

Үүнд: Худаг орчмын бэлчээрт малаа бэлчээхдээ худгийн эргэн тойрны 1,5 км зайн бэлчээрийг баримжаалан авч 8 хэсэгт хуваах, нэг хэсгийн талбай нь 90—100 га орчим хэмжээтэй байх ба нэг хэсэгт 4—5 хоног малаа бэлчээж дараагийн хэсэгт шилжинэ.

Худгийн орчим 0,5 км-ийн хүрээний бэлчээрт малаа тогтоож бэлчээлгүй зөөхөн услах үед сөрмүүчлэн идүүлж өнгөрдөг.

Энэ нь бэлчээрийн ургамлыг хэт тахлагдхаас сэргийлэх боломжтой юм. Улирлын бэлчээрийг суурь бүрт хуваарилан өгдөг. Нэгэнт хуваарьт

улирлын бэлчээртээ буусан малчин бэлчээрийн нэг захыг зурваслан дагуулж өдөр, өдөрт хэсэгвөн улиралд малд тохирох бэлчээрээ сонгон авч бэлчээрийн хооронд урт богино нүүдэл, хөнгөн маягийн зөөвөр хийхээс гадна нэг нутгийн бэлчээрээ тодорхой системтэй ашигладаг байна.

Энэ нь бэлчээрийг бүрэн гүйцэт ашиглах боломж өгдөг байна. Мөн бэлчээрээ цагаарын нөхцлөөс хэд хэдэн хэсэгт баримжаалан хуваахаас гадна зуны улиралд малаа салхи дагуулан бэлчээрт гаргаж сөргүүлэн хотлуулах бөгөөд үлдээс хойш бол салхи сөргүүлэн бэлчээрт гаргаж уруудуулан хотлуулдаг. Ингэхэд хонь халууцан бэлчээрт хоролгүй, удаан идэшилдэг ашигтай аж. Иймээс энэ аргыг цагуур, бэлчээрийн хувьд адил төстэй манай орны нөхцөлд авч хэрэглэх нь зүйтэй юм.

Б. БАЯРАА



Дээрх тэнгэрийн од тоолон
Дэлхий газрын үндэс тоолон
Эмнэг хангал чардан булгивч
Ээжийн охин эмээл дээрээ

Эрэлхэг зоригийн дээдийг гай-
хуулна
Залуу охины гэгээн царайд
Залгамж үеийн маань золбоо
гэрэлтэнэ

Д. ТОВУУ-гийн авсан гэрэл зураг

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ